



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/479

Номгон

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3" а" дахь заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан тусгаарлан ажиглах байранд ажиллаж байгаа төрийн албан хаагчид болон тусгаарлагдсан иргэдийн хоолны зардал болох 27.406.060 (хорин долоон сая дөрвөн зуун зургаан мянга жаран)төгрөг, постонд гарч эргүүл хийж, үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын хоолны зардал болох 40.466.000 (дөчин сая дөрвөн зуун жаран зургаан мянган) төгрөг, нийт 67.872.060 (жаран долоон сая найман зуун далан хоёр мянга жаран) төгрөгийг тооцооллыг үндэслэн холбогдох цэцэрлэгүүдэд тус тус олгосугай.

2.Дээрх арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Энхтөр)-т үүрэг болгосугай.

3.Цэцэрлэгүүдэд олгох 67.872.060 (жаран долоон сая найман зуун далан хоёр мянга жаран) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210113